



## ОЮУТНУУДЫН ЭХ ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ("Монгол хэл, бичиг, найруулга зүй" хичээлийн жишээн дээр)

Л.Эрдэнэчимэг<sup>а</sup>, Б.Хадбаатар<sup>б</sup><sup>а</sup>МУБИС-НХУС, багш, доктор<sup>б</sup>МУБИС-Багшийн сургууль, Хөтөлбөрийн албаны дарга, докторХолбоо барих зохиогч: [erdenechimeg@msue.edu.mn](mailto:erdenechimeg@msue.edu.mn)

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

### Хураангуй

Их, дээд сургуульд элсэгчид, суралцагчдын сургалтын чанарт хувь хүний чадвар, хүсэл тэмүүлэл, багш нарын заах арга зүй, хөтөлбөрийн чанар, орчин гэх зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Тухайлбал, суралцагчийн хувь хүний чадваруудын нэг бол эх хэлний боловсролын түвшин юм. Энэхүү бичил судалгаа нь суралцагчдын зөв бичих чадварыг үнэлэх, цаашдын арга замыг тодорхойлохыг зорилоо. Судалгаанд багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан мэргэжлээр суралцаж буй 1-3 дугаар курсийн 249 оюутан оролцсон.

### Түлхүүр үг

Монгол хэл бичиг, найруулга зүй, хөтөлбөр, суралцагчдын зөв бичих чадвар, нөлөөлөх хүчин зүйл, арга зам

### Удиртгал

Сүүлийн үед эх хэлний асуудал олон нийтийн анхаарлын төвд байгаа билээ. Учир нь монголчууд бид шинэ мэдлэгийг шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийг ашиглан, хэвлэл мэдээллийн олон эх сурвалжаас авах болсон. Мөн эх хэлэнд хандах хандлага өөрчлөгдөн, даяарчлал, нийгмийн ороо бусгаа байдлаас үүдэлтэйгээр харь хэлний үнэлэмж дээшилсэн. Иргэд, олон нийт “Сүүлийн үеийн багш нарын мэдлэг чадвар, заах арга зүй, ярих бичих чадвар сул байгаа нь эх хэлний боловсролд нөлөөлж байна” хэмээн үнэлэх болсон.

Энэхүү байдалд дүн шинжилгээ хийн, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх шаардлага нэн чухлаар тавигдаж байна. Бид энэхүү бичил судалгаагаар “Монгол хэл бичиг, найруулга зүй” хичээл судалж буй оюутны зөв бичих чадварыг үнэлж, дүн шинжилгээ хийхийг зорьсон болно. Учир нь тус сургуульд элсэн суралцагчид нэгдүгээр курстээ дээрх хичээлийг заавал судалдаг бөгөөд хичээлийн агуулгад “зөв бичих чадвар” гэсэн бүлэг байдаг билээ.

Зөв унших, уншиж ойлгосноо зөв ярихаас гадна, өөрийн үзэл бодлоо илэрхийлэхэд бичгийн боловсрол туйлын чухал юм. “Хүн бүхэн бичиг үсгээр дамжуулан, мэдлэг хүртэж, эзэмшсэн мэдлэгээ бусадтай хуваалцаж, амьдарч буй нийгмийнхээ үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог төдийгүй тухайн хүний бичгийн боловсролын түвшин, төрөлх хэлээ эзэмшсэн байдлыг тодорхойлох нэг хүчин зүйл нь зөв бичих чадвар юм” (Даваасүрэн. 2021) хэмээснээс харж болно.

Эрх зүйн олон бичиг баримтад эх хэл, эх хэлний боловсрол, зөв ярих бичих чадвар чухалчилсныг харж болно. Тухайлбал, Монгол Улсын Их хурлаас баталсан “Монгол хэлний тухай хууль” (2015), Монгол Улсын Засгийн газрын “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай” тогтоол (2013/37), Төрийн хэлний зөвлөл “Кирилл бичгийн стандарт тогтоох тухай тогтоол” (2011/01), Монгол Улсын Их хурлаас баталсан (2020/52) “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д, Монгол Улсын Их хурлаас баталсан (2023) “Боловсролын ерөнхий хууль” зэрэгт хуульчлан оруулжээ.


Монгол Улсын Их хурлаас баталсан (2023) “Боловсролын ерөнхий хууль”-ийн 6.4-т: Энэ хуулийн 6.2-т заасан боловсролын сургалтын байгууллага суралцагчид монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, монголын түүхийн агуулгыг заавал монгол хэлээр эзэмшүүлнэ; 14.4-т: Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ; 14.4.1-д: Монголын түүх, монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, төлөвшил-ийг эзэмшүүлнэ гэдгийг тусгайлан зүйл болгон оруулжээ. Энэ мэт хууль, эрх зүйн бичиг баримтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Боловсролын их сургууль 2010 оноос эхлэн сургалтын төлөвлөгөөнд “Монгол хэл бичиг, найруулга зүй”-н хичээл оруулж, Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын “Хичээлийн жагсаалт батлах тухай” (2014/А/285) тушаалаар бакалаврын сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт дахь “Монгол хэл бичиг, найруулга зүй” (S.ML101) батлуулсан бол, НХУС-ийн Монгол хэлний тэнхимийн багш нар тухайн хичээлийн стандарт, хөтөлбөрийг боловсруулах, хичээлийн агуулгын хүрээг тогтоох ажлыг хийн, профессор А.Цог-Очир төрийн өмчийн их, дээд сургуулийн багш нарт үзүүлэх хичээл заасан. Мөн тус тэнхимийн багш нар 2015 онд сурах бичиг боловсруулж, жил бүр багшлах үйлдээ дүн шинжилгээ хийн ажиллаж байна.

## Үндсэн хэсэг

“Монгол хэл бичиг, найруулга зүй” хичээлийг заах явцдаа үйлийн бичил судалгаанууд хийж, хичээлийн агуулга, арга зүйгээ шинэчилж байдгийн нэг нь улирал бүр тухайн хичээлийг судалж буй оюутнуудаас зөв бичих чадварын судалгаа авдаг. Энэ хичээлийн жилийн судалгаанд Боловсрол судлалын сургуулийн I курсийн 167 оюутан, Багшийн сургуулийн III курсийн 60 оюутан, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн I курсийн 22 оюутан хамрагдсан. Энэхүү гурван сургуулийн оюутнуудыг дараах шалтгаанаар судалгаанд оролцуулсан. Үүнд, БСС-ийн оюутнууд тухайн хичээлийн хөтөлбөрийг судалж эхэлж байгаа бол, харин НХУС, БС-ийн оюутнууд мэргэжлийн “Зөв бичих зүй”, “Зөв бичих, зөв дуудах зүй” хичээл судалсан. Өөрөөр хэлбэл, МУБИС-д элсэгчдийн гарааны болон үйлийн явцын


үнэлгээ хийж, зөв бичих чадварт гарсан ахиц, өөрчлөлтийг тогтоохыг хичээсэн юм. Судалгаанд оролцогчдын алдааны давтамжийг дараах байдлаар үзүүлэв.

График 1. Боловсрол судлалын сургуулийн оюутнуудын хамгийн олон алдаж буй дүрэм




Графикаас МУБИС-д элсэгчдийн зөв бичих чадвар тун тааруу байгааг харж болохоор байна. Учир нь судалгаанд хамрагдсан 167 оюутан 2-33 алдаж байна. Алдааг нь дүрмээр нь багцалбал, §28 (нэгэнт гээсэн балархай эгшгийг дахин сэргээхгүй), §17 (заримдгийн араас орсон заримдаг эгшигтэй), хэд хэдэн дүрмийн нийлэмж (-чих бүтээвэртэй холбоотой дүрэм), §37 (нэрээс үйл үг бүтээх Л дүрэм), (зарим бүтээврийг зөв бичих дүрэм), §29 (ирээдүй цагаар тодотгон холбох -Х бүтээврийн дүрэм) зэрэг дүрмийг хамгийн олон давтамжтай байна. Тухайлбал, -чих бүтээвэртэй 3 үгийг судалгаанд оролцогчдын 61.87% нь алдсан байна.

График 2. Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн оюутнуудын хамгийн олон алдаж буй дүрэм



Үүнээс харахад, алдааны давтамж бага ч, §28 (нэгэнт гээсэн балархай эгшгийг дахин сэргээхгүй), §17 (заримдгийн араас орсон заримдаг эгшигтэй), хэд хэдэн дүрмийн нийлэмж (-чих бүтээвэртэй холбоотой дүрэм), §37 (нэрээс үйл үг бүтээх Л дүрэм) зэрэг дүрмийг хамгийн олон давтамжтай алджээ.


График 3. Багшийн сургуулийн оюутнуудын хамгийн олон алдаж буй дүрэм давтамж



Энэхүү судалгааг нэгтгэн үзвэл: §17 (заримдгийн араас орсон заримдаг эгшигтэй), хэд хэдэн дүрмийн нийлэмж (-чих бүтээвэртэй холбоотой дүрэм), §27 (гээгдэх эгшигийн дүрэм), §48 (гадаад үгийг бичих дүрэм) зэрэг дүрмийг хамгийн олон давтамжтай алдсан байна.

Энэхүү гурван бичил судалгааг нэгтгэж үзвэл, оюутнууд нь §28 (нэгэнт гээсэн балархай эгшигийг дахин сэргээхгүй), §17 (заримдгийн араас орсон заримдаг эгшигтэй), хэд хэдэн дүрмийн нийлэмж (-чих бүтээвэртэй холбоотой дүрэм) дүрэмд хамгийн олон давтамжтай алджээ. Иймээс эдгээр дүрмийг сайтар ухааруулж ойлгуулах хэрэгтэй байна.

График 4. Судалгаанд хамрагдсан оюутнуудын нэгтгэл Хамгийн олон давтамжтай алдаа



Судалгааны дараа оюутнуудын дунд “Бид яагаад алдаатай бичээд байна вэ?” хэлэлцүүлэг зохион байгуулахад гол шалтгаан нь “юм уншихгүй”, “ном уншихгүй”,

“үгийн утга ойлгохгүй байгаа”-д оршино гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Үүнийг 167 оюутны 38 нь л сүүлийн нэг жилийн дотор нэг ном уншсан гэснээс харж болно.

## Дүгнэлт

Сургалтын чанарт багш, суралцагчдын оролцоо, хөтөлбөр, сургалтын орчин зэрэг олон зүйл нөлөөлдөг. Дээрх судалгаануудаас харахад, багш мэргэжлээр суралцагчдын “ЗӨВ БИЧИХ ЧАДВАР”-ыг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй болжээ. Үүнд тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг багш бүрийн оролцоо, хандлага чухал байна. Учир нь зарим багш нар их сургуульд зөв бичих зүй ярих нь утгагүй гэдэг ч, “төгсөгчдийн маань үнэлэмжийн нэг шалгуур нь тэдний ярих, бичих чадвар юм” гэдгийг ухаармаар. Мөн сургалтын хөтөлбөр дэх агуулгын багтаамжийг эргэн харах шаардлагатай байна.

Орчны хувьд, суралцагчдыг цахим толь ашиглаж сургах, цахим орчинд бүтэн үгээр, кириллээр бичих дадалтай болоход багш бүр анхаарч, шаардлага тавьдаг байх нь чухал байна. Суралцагчид ч эх хэлний чадвараа дээшлүүлэх нөхцөл, боломжууд байна. Тухайлбал,

- Бичгийн хэлний зөв бичих дүрмийн алдаа шалгах “Болор дуран” программ (2016)
- Монгол хэлний дүрмийн алдаа шалгагч (spellcheck.gov.mn)
- Дүрмийн болон үг үсгийн алдааг шалгах нь (youtube.com) хэрхэн ашиглах талаар хичээл
- “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” (2018) <http://toli.gov.mn/>
- Гар утсандаа ‘Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь’ программ
- <https://www.medle.mn/>
- Зөв бичих чадварыг дэмжсэн олон нийтийн группүүд

## Ном зүй

Даваасүрэн,Н. (2021). *Монгол кирилл бичгийн зөв бичих дүрмийн интеграцчилсан арга зүйн судалгаа, туршилт, үр дүн*. Докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар.

Дамдинсүрэн,Ц., Осор,Б. (1984). *Монгол үсгийн дүрмийн толь*. Улаанбаатар.

Оюун,Ц. (2013). *Зөв бичгийн дүрмийн тогтолцоот хураамж-3*. Улаанбаатар.

Хэлний бодлогын үндэсний зөвлөл. (2018). *Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь*. Улаанбаатар.

Эрдэнэчимэг,Л., Сарангэрэл,Р., Бямбацэцэг,Ч. (2023). *Эх хэлний хэрэглээ, соёл*. Улаанбаатар.

Эх хэл бичиг (2013/2014). Олон нийтийн хэлний боловсролд зориулсан сэтгүүл, Улаанбаатар. 2013.

**CURRENT STATE OF STUDENTS' MOTHER LANGUAGE  
EDUCATION  
(On the example of the Mongolian language, writing, composition course)**

<sup>a</sup>Erdenechimeg L., <sup>b</sup>Khadbaatar B.

<sup>a</sup>Ph.D, teacher, MNUE;

<sup>b</sup>Head of the Program Office, Ph.D, MNUE

Corresponding author: [erdenechimeg@msue.edu.mn](mailto:erdenechimeg@msue.edu.mn) 

**Summary**

Many factors such as individual abilities and passions, teachers' teaching methods, program quality, and environment influence the quality of learning by students and applicants to universities and colleges. One of the individual abilities of the learner is the level of education in the mother tongue. This micro-research aims to assess students' writing skills and identify ways forward. 249 students of the 1st-3rd year studying to be teachers, psychologists and social workers participated in the research.

**Keyword**

Mongolian grammar, composition, program, students' ability to write correctly, influencing factors and methods